



## МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,  
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл: info@mof.gov.mn

Вэбсайт: www.mof.gov.mn

2023.05.12 № 03/3178  
танай -ны № -т

Гомдол хянасан тухай

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН САНХҮҮ, АЖ АХУЙН  
АЛБАНД ✓

*Xa X-*  
*Машинад өвөр. Хүчлийн  
хуралд уласан дотуу  
шишдээр.*  
*2023.05.15*

Танай байгууллагаас зарласан ЦЕГСААА/202301002 дугаартай “Цагдаагийн байгууллагын даатгалын үйлчилгээ” үзүүлэгчийг сонгох тендер шалгаруулалтын 1, 2 дугаар багцад оролцсон “Ард даатгал” ХК-аас гаргасан гомдлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 55 дугаар зүйлийн 55.2 дахь хэсэг болон Сангийн сайдын 2019 оны 131 дүгээр тушаалаар баталсан “Тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам”-д заасны дагуу захиалагчаас ирүүлсэн холбогдох баримт материалд үндэслэн хянан үзлээ.

“Ард даатгал” ХК-ийн гомдолд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Мэдээлэл лавлагаа, дүн шинжилгээний хэлтэст тус компаниас 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр гаргасан албан бичгийн дагуу цахим системд өр төлбөргүй гэсэн төлөвт оруулсан, мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын иргэн, хуулийн этгээдэд өр төлбөргүй тухай тодорхойлолтыг тендерт хавсаргасан байхад тус компанийн ирүүлсэн тендерээс татгалзсан нь үндэслэлгүй, захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон “Мөнхдаатгал” ХХК, “Хаандаатгал” ХХК-ийн ирүүлсэн тендерүүд тендерийн баримт бичгийн холбогдох шаардлагад нийцээгүй байхад гэрээ байгуулах эрх олгосон захиалагчийн шийдвэрийг тус тус хянан үзэхийг хүссэн байна.

Гомдолд дурдсаны дагуу “Ард даатгал” ХК-ийн ирүүлсэн тендерийг хянан үзэхэд захиалагч Сангийн сайдын 2019 оны 255 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ын 3.7-д “Захиалагч цахим системтэй холбогдсон мэдээллийн сангаас дараах журмаар ирүүлсэн мэдээллийг тендер хянан үзэхэд үндэслэл болгоно: 3.7.2.Шүүхийн тусгай архивын тодорхойлолт, шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд өртэй эсэх тодорхойлолтыг тендерт оролцогч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө цахим системээр дамжуулан авч цахим системийн холбогдох хэсэгт зааварчилгааны дагуу холбосон байх.” гэж заасны дагуу худалдан авах ажиллагааны цахим систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-ээс “Ард даатгал” ХК-ийн мэдээллийг шалгахад тус компани нь шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд төлбөртэй тухай 2023 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн тодорхойлолтод үндэслэн тендерийг хянан үзсэн байна.

“Ард даатгал” ХК-ийн ирүүлсэн тендерээс тендерийн баримт бичгийн тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 16.2.1-д “Шүүхийн тусгай архивын лавлагаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолтыг цахим хэлбэрээр авна.”, ТШЗ

9766006717

16.2.2-т “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт авах хүсэлтийг тендерт оролцогч Худалдан авах ажиллагааны цахим систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-д өөрийн үндэсний тоон гарын үсэг ашиглан тендерийн нээлттээс өмнө хүчин төгөлдөр тодорхойлолтыг цахим хэлбэрээр ирүүлнэ.” гэсэн шаардлагад нийцээгүй гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлтэй байна.

Гомдолд дурдсаны дагуу тендер шалгаруулалтын 1 дүгээр багцад захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон “Мөнхдаатгал” ХХК-ийн ирүүлсэн тендерийг хянан үзлээ.

1.“Мөнхдаатгал” ХХК тендер илгээх 1 дүгээр маягтыг худалдан авах ажиллагааны цахим систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-д тоон гарын үсгээр баталгаажуулан ирүүлсэн байгаа нь тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 16.1-д “Тендерт оролцогчтой холбоотойгоор хуулийн 14.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу хуульд заасан ерөнхий нөхцөлийг хангасан байна. Тендерт оролцогч нь ерөнхий нөхцөлийг хангасан тухай мэдэгдлийг V бүлгийн Маягт 1-ийн дагуу ирүүлнэ.” гэж заасан шаардлагад нийцсэн гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлтэй байна.

2.“Мөнхдаатгал” ХХК-аас ирүүлсэн ижил төстэй даатгалын гэрээний мэдээллийн агуулга нь тендерийн баримт бичгийн 6 дугаар маягтад нийцсэн байх тул тус компаниас ирүүлсэн маягтыг тендерийн баримт бичгийн тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 17.6.4-т “Сүүлийн 2 жил (2021, 2022)-ийн хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний талаарх мэдээллийг V бүлгийн Маягт 5-аар доорх зааврын дагуу ирүүлнэ.” гэсэн шаардлагад нийцсэн гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлтэй байна.

3.“Мөнхдаатгал” ХХК-ийн тендерийн 15 дугаар хавсралтад үйл ажиллагааны хуваарь, даатгалын хураамж шилжүүлэх хуваарь, даатгалын үйлчилгээ, гүйцэтгэх арга барил, хохирлыг барагдуулах явцын бүдүүвч гэсэн баримт бичгийг ирүүлсэн нь тендерийн баримт бичгийн тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 17.6.5-д “Ажил гүйцэтгэх үе шатны хуваарийг баталгаажуулан ирүүлнэ.” гэсэн шаардлагад нийцсэн гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлтэй байна.

4.Тендерийн баримт бичгийн тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 17.6.2-т “Үйлчилгээ гүйцэтгэхэд шаардлагатай хүний нөөцийн мэдээлэл: Шаардана.” гэж заасан байна.

Тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 17.6.2-т “гэрээг хэрэгжүүлэх удирдах, хяналт тавих, тодорхой үйлчилгээг гүйцэтгэх ажилтан, ажилчдын боловсрол, мэргэжлийн ур чадвар, туршлагын талаарх ТӨХ-д шаардсан бол V бүлгийн Маягт 4-ийн дагуу бэлтгэсэн мэдээлэл” гэсэн шаардлагад хамаарах хүний нөөцийн мэдээлэл бүхий маягтыг “Мөнхдаатгал” ХХК-аас ирүүлээгүй байгаа нь дээр дурдсан тендерийн баримт бичгийн тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 17.6.2-т заасан шаардлагад нийцэхгүй байна.

Гомдолд дурдсаны дагуу тендер шалгаруулалтын 2 дугаар багцад захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон “Хаандаатгал” ХХК-ийн ирүүлсэн тендерийг хянан үзэхэд тендерийн баримт бичгийн тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 17.6.2-т “Үйлчилгээ гүйцэтгэхэд шаардлагатай хүний нөөцийн мэдээлэл: Шаардана.” гэж заасан байна.

Тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 17.6.2-т “гэрээг хэрэгжүүлэх удирдах, хяналт тавих, тодорхой үйлчилгээг гүйцэтгэх ажилтан, ажилчдын боловсрол, мэргэжлийн ур чадвар, туршлагын талаарх ТӨХ-д шаардсан бол V бүлгийн Маягт 4-ийн дагуу бэлтгэсэн мэдээлэл” гэсэн шаардлагад хамаарах хүний нөөцийн мэдээлэл бүхий маягтыг “Хаандаатгал” ХХК-аас ирүүлээгүй байгаа нь дээр дурдсан тендерийн баримт бичгийн тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 17.6.2-т заасан шаардлагад нийцэхгүй байна.

Иймд захиалагчийн 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 14в/784 тоот шийдвэрийн “Мөнхдаатгал” ХХК, “Хаандаатгал” ХХК-д гэрээ байгуулах эрх олгосон хэсгийг хуулийн 55 дугаар зүйлийн 55.3.1 дэх заалтын дагуу хүчингүй болгож байна.

Дээрх тендер шалгаруулалтын 1, 2 дугаар багцуудын үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийхийг хуулийн 55 дугаар зүйлийн 55.3.3 дахь заалтад үндэслэн мэдэгдье.

Хуулийн 55 дугаар зүйлийн 55.4 дэх хэсэгт заасны дагуу захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг түр түдгэлзүүлсэн шийдвэрийн хугацаа үүгээр дуусгавар болно.

Хувийг: “Ард даатгал” ХК-д.

ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Ж.ГАНБАТ